



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2026 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах  
арга хэмжээний төлөвлөгөө (2026-2028 он) батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.5, 8.1.6 дахь заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах арга хэмжээний 2026-2028 оны төлөвлөгөөг нэгдүгээр, төлөвлөгөөний хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нэгдсэн, мэргэжлийн арга зүйгээр ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан)-т, салбарын бодлого, хөтөлбөрт тусгахыг Бодлого, төлөвлөлтийн газар (Б.Туяа)-т, шаардлагатай санхүүжилтийг жил бүр төсөвт тусгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Санхүү эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газар (Л.Мөнхцэцэг)-т, улсын хэмжээнд зохион байгуулж, олон улсын дэмжлэг авч ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв (Л.Баттөр)-д тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллаж өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагын тайланг нэгтгэн жил бүрийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан)-т ирүүлж байхыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, төрөлжсөн мэргэшлийн төв бусад холбогдох эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат)-д даалгасугай.

САЙД



Ж. ЧИНБҮРЭН

141260356

## ХАЛДВАРТ БУС ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ (2026-2028 ОН)

### НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Дэлхий нийтэд урьдчилан сэргийлэх боломжтой 4 төрлийн халдварт бус өвчин (ХБӨ) (зүрх судасны өвчин, хорт хавдар, чихрийн шижин, амьсгалын замын бөглөрөлт архаг эмгэг)-ний улмаас жилд 41 сая хүн нас бардаг ба энэ нь нийт нас баралтын 74 хувийг эзэлж, үүнээс 17 сая хүн цаг бусаар буюу 70 хүртэлх насандаа эндэж байна. Эдгээр цаг бусын эндэгдлийн 86 хувь нь бага болон дунд орлоготой орнуудад бүртгэгдэж байна.

ХБӨ, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх, эрт илрүүлж, эмчлэх, салбарын хариу арга хэмжээ авах чадамж болон бусад салбарын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар ХБӨ-өөр өвдөх эрсдэлийг 90 хувь, цагаас өмнө нас барах, хөдөлмөрийн чадвар алдах эрсдэлийг 50 хувь, зүрх судасны өвчнөөр өвдөх эрсдэлийг 80 хувь, 2-р хэлбэрийн чихрийн шижингээр өвдөх эрсдэлийг 90 хувь бууруулах боломжтойг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ) тогтоосон.

Нэгдсэн Үндэсний Байгууллага болон Дэлхийн банкны гишүүн орнуудын Тогтвортой Хөгжлийн Зорилтын (ТХЗ) хэрэгжилтийн үнэлгээгээр 2024 оны гүйцэтгэлийн индексийн дэлхийн дундаж оноо 66.1 буюу “дунд” түвшний ахицтай байгаа хэдий ч олон улс оронд хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэн ХБӨ-тэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэхийг зөвлөсөн. Монгол улсын хувьд энэхүү үнэлгээгээр 66.3 оноотойгоор 99 дүгээрт жагсаж, өмнөх оноос 7 байраар урагшилж, эрүүл мэндийн зорилтын гүйцэтгэл “дунд” зэрэг буюу сайжирч байгаа гэж үнэлэгдсэн байна.

Монгол Улсын “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн Эрүүл мэндийн зорилтод “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлнэ” хэмээн тусгаж, 2030 он хүртэлх хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2.2.14-т “Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна” хэмээн заасан.

Монгол Улс хөгжлийн урт, дунд хугацааны зорилтод ХБӨ-өөс сэргийлэх, тэмцэх зорилтыг дэвшүүлж, Засгийн газраас “ХБӨ-өөс сэргийлэх, хянах” I үндэсний хөтөлбөр (2005-2009 он), II хөтөлбөр (2010-2015 он), III хөтөлбөр (2017-2021 он)-үүдийг батлан хэрэгжүүлж, 2018 оноос ХБӨ-өөс сэргийлэх, хянах үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, зонхилон тохиолдох ХБӨ-ий эмнэлзүйн заавар удирдамжийг батлан хэрэгжүүлж олон талт арга хэмжээг төрийн, олон улсын болон иргэний нийгмийн байгууллагын оролцоо, хамтын ажиллагаатайгаар

хэрэгжүүлснээр тус салбарын хариу арга хэмжээ авах чадамж дээшилж, иргэдийн эрүүл мэнддээ хандах хандлага сайжирч байгаа зэрэг тодорхой үр дүн гарч байна.

Гэсэн хэдий ч Монгол Улсын хүн амын дунд сүүлийн 30 гаруй жил ХБӨ, түүнээс шалтгаалсан нас баралт буурахгүй, хүн амын нас баралтын шалтгааны 85.9%-ийг ХБӨ эзэлж, жилд нас барж буй насанд хүрсэн 10 хүн тутмын 9 нь ХБӨ, осол гэмтлийн улмаас эндэж байгаад анхаарал хандуулж, дорвитой арга хэмжээ авах шаардлагатай байна. Тухайлбал: НҮБ-ын ТХЗ-д ХБӨ-ий улмаас цагаас эрт нас баралтыг 1/3-ээр буюу 25 хувиар бууруулах зорилт дэвшүүлсэн. Гэвч Монгол Улсын 30-70 насны хүн амын 4 төрлийн ХБӨ улмаас нас барах магадлал 35 байгаа нь дэлхийн дундаж (17.8)-аас 17.2, харин бүсийн дундаж (15.6)-аас 19.4-өөр тус тус өндөр байна.

2024 оны байдлаар хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаанд хоол боловсруулах тогтолцооны, амьсгалын тогтолцооны, зүрх судасны тогтолцооны, шээс бэлэгийн тогтолцооны өвчлөл болон гэмтэл, бэртэл, хордлого өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгаан болсон хэвээр байна.

Зүрх судасны тогтолцооны өвчний шалтгаант нас баралт хүн амын нас баралтын эхний байранд, өвчлөлийн гуравдугаар байранд сүүлийн 30 гаруй жил байгаа ба улмаар өсөх хандлагатай байна. Зүрх судасны тогтолцооны өвчлөлийн бүтцийг харахад 2024 оны байдлаар цусны даралт ихсэлт 45.9 хувь, зүрхний ишеми 15.9, тархины судасны өвчин 16.4, вен, тунгалгийн зангилааны өвчин 6.2, хэрлэгийн гаралтай өвчин 1.7 хувийг эзэлж байна. ЗСӨ-ий шалтгаант нас баралт 2024 оны байдлаар 31.9 хувь байгаа ба зүрх судасны тогтолцооны өвчний улмаас жил бүр 5500-6000 хүн нас барж, нас барсан хүмүүсийн 62.2 хувь нь эрэгтэйчүүд, 37.8 хувь нь эмэгтэйчүүд байна. Нас баралтын дийлэнх хувийг артерийн даралт ихсэлт, зүрхний шигдээс, тархины цус харвалт эзэлж байгаа нь анхаарал татсан асуудлын нэг болсоор байна.

Хүн амын нас баралтын шалтгаанд зүрх судасны өвчний шалтгаант нас баралт 10000 хүн амд 16.9, хавдар 13.2, осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 9.8, хоол боловсруулах тогтолцооны эмгэг 3.6, амьсгалын тогтолцооны эмгэг 2.9 байгаа нь тэргүүлэх 5 шалтган болсоор байгаа бөгөөд хүн амын нас баралт 2024 онд 18.1 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 5 хувиар, өмнөх оноос 3.4 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Гэмтэл, бэртэл, хордлого, гадны шалтгаант эмгэг нь хүн амын дунд өвчлөлийн тав дахь шалтгаан, нас баралтын гурав дахь шалтгаан болсон хэвээр байна. 2024 онд Монгол улсын хэмжээнд 222 564 осол гэмтлийн шинэ тохиолдол бүртгэгдэж өмнөх оноос 5.6 хувиар өсөж хамгийн их тохиолдолтой жил болсон байна. 2020-2024 онд бүртгэгдсэн осол гэмтлийн шинэ тохиолдлын 43.3 хувь нь унаж бэртсэн байгаа бол бол удаах тэргүүлэх шалтгаануудад амьгүй механик хүчинд өртөх, зам тээврийн осол, хүчирхийлэл, амьд механик хүчинд өртөх болон түлэгдэлт багтсан байна. Осол гэмтэл, гадны шалтгаан Монгол хүний нас баралтын

3 дахь шалтгаан болсоор байгаа бөгөөд 2024 оны байдлаар нийт нас баралтын 18.6 хувийг эзэлж байна. Зам тээврийн осол, амиа хорлолт, үйлдвэрлэлийн осол, бусдад хорлогдсон, бусад осол, тодорхой бус гэсэн шалтгаануудаар эрэгтэй хүмүүсийн нас баралт эмэгтэйгээс харьцангуй их байна.

Хоол боловсруулах замын өвчлөлийн шалтгаанд амны хөндий, эрүүний өвчлөл 45 хувьтай зонхилж байгаа бол амьсгалын замын өвчлөлд амьсгалын дээд замын цочмог халдварууд 39.5 хувь, цочмог бронхит 12.5 хувь, уушгины хатгаа 15.1 хувьтай байна.

ХБӨ-ийг нөхцөлдүүлэгч шалтгаан болсон анхдагч эрсдэлт хүчин зүйлс болох архи, тамхины хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, зохисгүй хооллолт зэрэг зан үйлийн эрсдэлт хүчин зүйлстэй тэмцэх хууль эрхзүйн орчныг сайжруулах арга хэмжээ авч байгаа боловч тархалт буурахгүй байна. Тухайлбал, ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг 15-64 насны хүн амын дунд тогтоох үндэсний тандалт судалгааг 2005 оноос эхлэн 4 удаа хийсэн бөгөөд 2019 оны "Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын IV судалгаа "(STEPS-2019)-ны судалгаагаар 15-64 насны хүн амын 3.9 хувьд л ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлс илрээгүй буюу ХБӨ-өөр өвчлөх эрсдэлгүй байсан. Хүн амын 24.2 хувь тамхи хэрэглэдэг, 34.8 хувь нь сүүлийн 1 сард архи согтууруулах ундаа хэрэглэсэн, 21.9 хувь хөдөлгөөний хомсдолтой, 83.4 хувь хоногт нэгжээс бага жимс, хүнсний ногоо хэрэглэдэг, давсны хэрэглээ 10.5 хувь байна.

Дээрх анхдагч эрсдэлт хүчин зүйлсээс шалтгаалсан бодисын солилцооны эрсдэлт хүчин зүйлсийн тархалт өндөр, буурахгүй байна. Тухайлбал, артерийн гипертензийн тархалт 44 хувь, 50,9 хувь нь илүүдэл жин, таргалалттай, 25.7 хувь нь цусан дахь глюкозын өөрчлөлттэй эсвэл глюкоз бууруулах эмчилгээ хийлгэж байгаа, сүүлийн 10 жилд цусны нийт холестерин хэмжээ ихэссэн хүний эзлэх хувь 2.6 хувиар өссөн, цусны триглицеридын түвшин ихэсч 31.1 хувьтай байна. Судалгаагаар хүн амын зан үйлийг өөрчлөх, бодисын солилцооны эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, сэргийлэх талаар эмч, эмнэлгийн ажилчдаас зөвлөгөө авсан байдал өмнөх судалгаатай харьцуулахад 1.2-1.4 дахин буурсан үзүүлэлттэй байгаа нь анхаарал татсан асуудлын нэг болж байгаа юм.

Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа ХБӨ, нас баралт, тэдгээрийг нөхцөлдүүлж байгаа эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулж, ХБӨ-ий улмаас цагаас эрт нас баралтыг 25 хувиар бууруулах ТХЗ-д хүрэхийн тулд эрүүл мэндийн салбарын тогтолцоо, үйл ажиллагааны хариу арга хэмжээ авах чадамж, байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ХБӨ-ий анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлсийг хяналтандаа авах "хаалга баригч"-ийн үүргийг сайжруулах, олон нийт, бусад салбарын түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх, ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлстэй тэмцэх сэргийлэх ДЭМБ-ын үр дүнтэй нь нотлогдсон шилдэг бодлогын

хувилбаруудыг хэрэгжүүлэх болон одоо хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

## **ХОЁР. ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД**

### **2.1 Зорилго**

Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл, цагаас эрт нас баралт, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийг эрүүл мэндийн салбарын хариу арга хэмжээ авах чадамж болон салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах замаар бууруулах, өсвөр үе, залуусын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, хоёрдогч урьдчилан сэргийлэлт болон сэргээн засах тусламж үйлчилгээний уялдааг сайжруулах замаар бууруулах

### **2.2 Зорилт, хүрэх үр дүн**

**2.2.1 Зорилт 1.** ХБӨ-өөс сэргийлэх, хянах эрхзүйн орчинг боловсронгуй болгох;

**Хүрэх үр дүн:** ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг бууруулах эрхзүйн орчин сайжирч, иргэдийн эрүүл зан үйлийг дэмжих орчин бүрдэнэ.

**2.2.2 Зорилт 2.** ХБӨ, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийн бүртгэл, мэдээлэл, хяналт, тандалтын тогтолцоог боловсронгуй болгож, дэвшилтэт технологи нэвтрүүлэх;

**Хүрэх үр дүн:** ХБӨ, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт, мэдээлэл, хяналт тандалтын цахим тогтолцоо сайжирч, бодлого, үйл ажиллагааны зохицуулалт, уялдаатай болно.

**2.2.3 Зорилт 3.** Халдварт бус өвчний чиглэлээрх эрдэм шинжилгээ, судалгааг өргөжүүлэн нотолгоонд суурилсан шийдвэр гаргах орчныг сайжруулах;

**Хүрэх үр дүн:** ХБӨ, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг бууруулах нотолгоонд суурилсан бодлого, үйл ажиллагаа сайжирна.

**2.2.4 Зорилт 4.** Эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлж, халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг бууруулах;

**Хүрэх үр дүн:** ХБӨ-ий нийтлэг эрсдэлт хүчин зүйлийн талаарх хүн амын мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэхэд нийгмийн салбаруудын оролцоо, хамтын ажиллагаа сайжирч, эрүүл аж төрөх, эрүүл зан үйлийг дэмжсэн нийгмийн зөв хандлага төлөвшинө.

**2.2.5 Зорилт 5.** Зонхилон тохиолдох ХБӨ-өөс сэргийлэх, хянах анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

**Хүрэх үр дүн:** Анхан шатны эрүүл мэндийн байгууллагын ХБӨ-ийг эрт үед нь хяналтанд авах "хаалга баригч"-ийн үүрэг сайжирч, ХБӨ, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлс болон бодисын солилцооны хам шинжийн хяналт сайжирна.

**2.2.6 Зорилт 6.** Зонхилон тохиолдох ХБӨ-ий эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний чанар, хүртээмж, эм, технологийн хангамжийг сайжруулах;

**Хүрэх үр дүн:** Хүн амын дунд зонхилон тохиолдох ХБӨ-ий менежмент сайжирч, эрүүл мэндийн салбарын байгууллагын нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан өвчнийг эрт үед нь илрүүлэх, эмчлэх, хүндрэлээс сэргийлэх чадавхи бэхэжнэ.

### **ГУРАВ. ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ**

- 3.1 Хүний амьдралын мөчлөг бүрт тохирсон судалгаа, нотолгоонд суурилсан байх;
- 3.2 Олон улсын байгууллагын холбогдох зорилт, бусад бодлого, хөтөлбөртэй уялдсан, нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх;
- 3.3 Төрийн бодлогын болон зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл, тэдгээрийн нийтлэг эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах залгамж чанарыг хадгалсан байх;
- 3.4 Иргэд, олон салбарын оролцоо, дэмжлэг, хамтын ажиллагааг хангасан байх;
- 3.5 Ил тод, нээлттэй байх, олон нийтийн оролцоог хангасан байх;
- 3.6 Хүний эрхийг хамгаалах, хэнийг ч үл орхигдуулах.

### **ДӨРӨВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- 4.1 Төлөвлөгөөний үйл ажиллагааны хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн нэгж хариуцаж, зохих үйл ажиллагаанд яамны бусад холбогдох нэгжийг оролцуулан, салбарын хамтын ажиллагааг хангана.
- 4.2 Төлөвлөгөөнд багтсан зонхилон тохиолдож байгаа ХБӨ-өөс сэргийлэх, хянах тусламж, үйлчилгээний менежментийг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв хариуцна. Тухайлбал, Зүрх судас өвчлөлөөс сэргийлэх, хянах тусламж, үйлчилгээний менежментийг Улсын гуравдугаар төв эмнэлэг (Зүрх судасны үндэсний төв), Чихрийн шижингээс сэргийлэх, хянах тусламж, үйлчилгээний менежментийг Улсын нэгдүгээр төв эмнэлэг (Чихрийн шижингийн төв), Амьсгалын замын бөглөрөлт өвчлөлийн менежментийг Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Тулгуур өвчний менежментийг АШУҮИС-ийн Монгол Японы эмнэлэг, Осол, гэмтлээс сэргийлэх, хянах тусламж, үйлчилгээний менежментийг Гэмтэл согог судлалын үндэсний төв тус тус хариуцаж ажиллана.
- 4.3 Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлстэй тэмцэх, сэргийлэх ажлыг Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хуульд заасны дагуу хэрэгжүүлж ажиллана.

4.4 Аймаг, дүүргийн эрүүл мэндийн газар нь ХБӨ, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлстэй тэмцэх, сэргийлэх ажлыг харьяалах салбартаа хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа бусад салбар, олон нийтийн оролцоог хангаж ажиллана.

4.5 Төлөвлөгөөний үйл ажиллагааны хэрэгжилтийг хариуцсан байгууллага бүр мэдээ, тайланг нэгтгэх, тайлагнах, үр дүнг тооцох үүрэг хүлээнэ.

#### **ТАВ. САНХҮҮЖИЛТ**

5.1 Улс, орон нутгийн төсөв

5.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгө

5.3 Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө

5.4 Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

5.5 Хандивлагч улс орон, гадаад, дотоодын төрийн ТББ, аж ахуйн нэгж, иргэдийн хандив

5.6 Бусад эх үүсвэр

#### **ЗУРГАА. ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ**

6.1 Төлөвлөгөөний үйл ажиллагааны явцын хяналт-шинжилгээг 2027 онд, төгсгөлийн үнэлгээг 2028 онд хийнэ.

6.2 Төлөвлөгөөний үйл ажиллагааны хэрэгжилтийн явцад жилд 4-өөс доошгүй удаа дэмжлэгт хяналтыг зохион байгуулна.

6.3 Төлөвлөгөөнд багтсан зонхилон тохиолдох ХБӨ-өөс сэргийлэх, хянах үйл ажиллагааны тайланг тухайн өвчний менежментийн асуудал хариуцсан төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх, хянах үйл ажиллагааны тайланг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, жил бүрийн эрүүл мэндийн үзүүлэлт, тоо мэдээг Эрүүл мэндийн хөгжлийн төв тус тус ЭМЯ-д жил бүрийн 1 сард багтаан тайлагнана.

6.4 Хяналт, шинжилгээ үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэж болно.

**"ХАЛДВАРТ БУС ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ, ХЯНАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ" (2026-2028 ОН)**

Эрүүл мэндийн сайдын 2026 оны  
03 дугаар сарын 06 өдрийн тушаал  
тушаалын нэгдүгээр хавсралт



№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Санхүүгийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин, он	Зорилтот түвшин			Төсөв төгрөгөөр			Нийт төсөв (сая)	Хэрэгжүүлэгч байгууллага	Үндсэн Хамтрагч	Оролцогч
					2026 он	2027 он	2028 он	2026 он	2027 он	2028 он				
<b>Зорилт 1. Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах бодлого, эрхзүйн орчинг боловсронгуй болгох</b>														
1	Хүнсний бүтээгдэхүүний харицдаг, сав баглаа, боордлын нүүрэн талд эрүүл хүнснийг илэрхийлэх "эрлэн дохио"-ны өнгөөр (Улаан, шар, ногоон өнгөөр) ялгасан тэмдэглэгээ байршуулах асуудлыг Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуульд тусгах асуудлыг судлах, хэлэлцүүлэх	Улсын төсөв, ЗМДС, ОУБ	Хуульд өөрчлөлт оруулах санал Хэрэглэгчийн ойлголтын судалгаа	Хуулийн зохицуулалт байхгүй	Хүнсний тухай хуульд санал өгсөн байна	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын тухай хуульд санал өгсөн байна	-	9.0	9.0	-	18.0	ЭМЯ, ХХААХУ Я	НЭМҮТ	ОУБ, ТББ
2	Эрлэн дохионы өнгөөр ялгасан тэмдэглэгээ бүхий эрүүл хүнсний бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөлөх талаар санал боловсруулж, гаалийн тариф, татварын тухай хуульд санал өгөх	Улсын төсөв, ЗМДС, ОУБ	Хуульд өөрчлөлт оруулах санал, судалгаа Багтаагдсан дагалдах журам	Хуульд тусгагддаггүй байна	Эрлэн дохионы өнгөөр ялгасан тэмдэглэгээ бүхий эрүүл хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, экспортогч улс орны туршлагыг судалсан байна	Зах зээлийн нийлүүлэлтийн талаарх мэдээлэл, судалгааны үр дүнд шинжилгээ хийсэн байна	Хуульд санал өгсөн байна	-	-	18.0	18.0	ЭМЯ, СЯ	ХХААХУЯ, Г.ЕГ, НЭМҮТ	ОУБ, ТББ
3	Зар сурталчилгааны тухай хуульд санал өгөх	Эрүүл мэндэд хэт төсөв, хэт ЗМДС, тран-ЗМДС, ОУБ	Хуульд өрсөн санал	Эрүүл мэндийн бус хүнсний бүтээгдэхүүн болгох хэт орчулан чихэрлэг, транс тос, архи согтууруулах ундааны маркетингийг хязгаарлах асуудлаар ДЭМБ-ын бодлогын баримт бичгийг судалсан байна	Зар сурталчилгаа нь тухай хуульд өрсөн байна	Зар сурталчилгааны тухай хуульд санал өгсөн байна	-	-	18.0	18.0	ЭМЯ, ЦХИХХ Я	НЭМҮТ, ХХЗГ, ОӨУХА, ШӨХТГ	ОУБ, ТББ	
4	Эрүүл мэндэд бус хэргийн хүнсний бүтээгдэхүүнд онцгой албан татвар	Улсын төсөв, ЗМДС, ОУБ	Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал	Онцгой албан татварын тухай	Эрүүл мэндэд хэргийн бус хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх	Бус төрлийн чихэрлэг ундаа, үйлдвэрлэх	Архи, тамхины онцгой албан татварыг 2030 оноос эхлэн хүн	-	-	18.0	18.0	ЭМЯ, ХХААХУ Я	СЯ, Г.ЕГ, ОУБ, ТББ	

№ хэмжээ	Зорилтыг хэрэгжүүлэх арга	Санхүүгийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Сурь түвшин, он	Зорилтот түвшин			Төсөв төгрөгөөр			Нийт төсөв (сая төг)	Хэрэгжүүлэгч байгууллага		
					2026 он	2027 он	2028 он	2026 он	2027 он	2028 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч
	НОГДУУЛАХ блоговоруулах асуудлыг судлах	санал	Батлагдсан дагалдах журам	Хуулиар хэт чихэрлэгт үндсэнд 2024.06.05-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр татвар 20%, транс тосонд онцгой албан татваргүй байна	Бүтээгдэхүүний жагсаалт гаргах, ДЭМБ, бусад улс оронд хэрэгжүүлж буй боллолыг судалсан байна	Транс тосонд ногдуулах татварын хэмжээг бүтээгдэхүүний үнийн 25% хүртэл болгох, татварыг хүн амын орлогтын өсөлтийн түвшинтэй үйлдүүлэх хууль зрхгүйн орчныг судалсан байна	амын орлогтын өсөлттэй үйлдүүлэх асуудлын талаар ДЭМБ-ын зөвлөмж, аргачлалыг судалсан байна	-	9.0	9.0	ЭМЯ	НЭМҮТ, СЭМҮТ	ОУБ, ТББ	
5	Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах	Тамхины хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх сан бий болгох Олон нийтийн газар, байгууллагын дотоод орчинг 100 хувь тамхигүй орчин болгох	Улсын төсөв, ЭМДС, ОУБ Хуульд нэмэлт, өөрчлөлт орсон байна Хяналт шалгалтаар буурсан зөрчлийн тоо	Хуульд тусгагддаггүй байна Тамхины хяналтын тухай хуулийн 5.1.7, 5.2.5, 9.1.5, 9.1.6, 6.4.1 дахь заалтаар зохицуулаг даж байна Хуульд тусгагддаггүй байна	Хуулийн төслийг УИХ-д өргөн барьж хэлэлцүүлсэн байна Хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ зохион байгуулсан байна	Хуулийн хэрэгжилтийг хангах арга хэмжээ зохион байгуулсан байна	-	9.0	9.0	ЭМЯ	НЭМҮТ, СЭМҮТ	ОУБ, ТББ		
6	Эрүүл хүнсний бүтээгдэхүүнд ногдуулсан татвараас Эрүүл мэндийг дэмжих сангийн эх үүсвэрийг	"Эрүүл мэндийг дэмжих сан"-ийн төсөв, эх үүсвэрт хэт ЭМДС, чихэрлэгт үндсэнд үйлдвэрийн транс тос агуулсан хүнсийг оруулах, архи, тамхинд	Улсын төсөв, ЭМДС, ОУБ Хуульд өрсөн санал Батлагдсан дагалдах журам	"Эрүүл мэндийг дэмжих тусгай сан нь архины онцгой албан татварын	Эрүүл мэндэд хор хөнөөлтэй хүнсний бүтээгдэхүүний хэрэгтээ татварын боллогоор бууруулах	Эрүүл мэндэд хор хөнөөлтэй хүнсний бүтээгдэхүүний хэрэгтээ татварын боллогоор үр эх	Эрүүл хүнсний бүтээгдэхүүнд ногдуулсан татвараас Эрүүл мэндийг дэмжих сангийн эх үүсвэрийг	-	19.0	19.0	ЭМЯ	НЭМҮТ, СЭМҮТ	ОУБ, ТББ	

№ хэмжээ	Зорилгыг хэрэгжүүлэх арга	Санхүүгийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин, он	Зорилгот түвшин			Төсөв төгрөгөөр)				Нийт төсөв (сая төг)	Хэрэгжүүлэгч байгууллага			
					2026 он	2027 он	2028 он	2026 он	2027 он	2028 он	Ундсэн		Хамтрагч	Оролцогч		
	Нэмэгдүүлэх санал боловсруулах	НОГДУУЛАХ ОАТ-ын хэмжээг 5 хувьд, эмийн импортын болон нэмэгдсэн өртгийн албан татварыг 3 хувьд хүргэх		1%, эмийн импортын гаалийн болон НӨАТ-ын 2%, тамхины онцгой албан татварын 2%, бусад хандив, тусламж зэргээс бүрдэж байна	ДЭМБ-ын зөвлөмж, аргачлалыг судалсан байна	дүн гаргасан бусад орны туршлагыг судалсан байна	нэмэгдүүлэх санал боловсруулсан байна									
7	Хүн амын суурьшлын бүс дэх архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх зөвшөөрлийн тоог бууруулах зохицуулалт хийх	Улсын төсөв, ЭМДС, ОУБ	Хүн амын суурьшлын бүс, архи, ХЭДХ-ийн сайдын 2023 онд худалдах, түүгээр үйлчлэх сарын 06-ны тусгай зөвшөөрлийн шийдвэрийг судалж сайжруулах хувилбар	ХХААХУ, Эрүүл мэнд, ХЭДХ-ийн сайдын 2023 онд худалдах, түүгээр үйлчлэх сарын 06-ны тусгай зөвшөөрлийн шийдвэрийг судалж сайжруулах хувилбар	Хүн амын суурьшлын бүс, архи худалдаалах, үйлчлэх цэгийн үйлчлэх хийж эрхийн хэрэглээ, хамаарал, тухалын өвчлөл, осол гэмтэл, осол хүчирхийлэл, архины хүртээмжийг бууруулах арга замын талаар хэлэлцүүлэг хийж зөвлөмж гарсан байна	Архины хүртээмжийг бууруулах арга замын талаар хэлэлцүүлэг хийж зөвлөмж гарсан байна	Архины хүртээмж, хэрэглээг бууруулах зорилгоор сайдын хамтарсан тушаалын төсөл боловсруулж батлуулсан байна	20.0	20.0	30.0	90.0	ЭМЯ, ХХААХУ	ХЭДХЯ, ГССТ, НЭМҮТ, СЭМҮТ	ОУБ, ТББ		
8	Хүний биений зохицолдлоого, бие бялдрын хөгжлийг тодорхойлох, үнэлэх, зөвлөгөө өгөх ажлыг орчин үеийн шинэ техник технологи ашиглан хэрэгжүүлэх удирдамж, аргачлал боловсруулж, бүсчилсэн сургалт зохион байгуулах	Бүтцийн	Боловсруулсан удирдамж, аргачлал, сургалтын сургалтанд хамрагдасдын тоо	Батлагдсан удирдамж, аргачлал байхгүй.	Удирдамж, аргачлал боловсруулж, бүсийн сургалтанд 100 оролцогч хамруулсан байна	3 бусад сургалт зохион байгуулж 300 байгуулж оролцогч хамруулсан байна.	2 бусад сургалт зохион байгуулж 200 оролцогч хамруулсан байна.	30.0	60.0	40.0	130.0	БТСХХ	Аймаг, нийслэлийн БТСХ	ТББ		
9	ХБЭ-ий өвчлөл, эрсдэлт хүчин зүйлс, хүндрэлээс сэргийлэх асуудлаар зорилгот бүлгийн хүн амын эрсдэлт зан үйлийг өөрчлөх	ЭМДС, ОУБ	Хүн амын эрсдэлт зан үйлийг өөрчлөх мэдээлэл	Зорилгот бүлэгт чиглэсэн ХБЭ-ий	Хүн амын эрсдэлт зан үйлийг өөрчлөх, үйлийг өөрчлөх зэрг өвчлөлөөс эрт	Хүн амын эрсдэлт зан үйлийг өөрчлөх, үйлийг өөрчлөх зэрг өвчлөлөөс эрт	Хүн амын эрсдэлт зан үйлийг өөрчлөх, үйлийг өөрчлөх зэрг өвчлөлөөс эрт	5.0	5.0	5.0	15.0	НЭМҮТ	ЭМЯ, ЭМХТ	ОУБ, ТББ		

№ хэмжээ	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Санхүүгийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Сурь түвшин, он	Зорилтот түвшин				Төсөв төгрөгөөр				Нийт Төсөв (сая төг)	Хэрэгжүүлэгч байгууллага					
					2026 он	2027 он	2028 он	2026 он	2027 он	2028 он	Үндсэн	Хамтрагч		Оролцогч					
	Мэдээлэл сургалт сурталчилгааг тогтмол зохион байгуулах		сургалт сурталчилгаа	эрсдэлт зан үйлийг өөрчлөх, эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл хангалтгүй хийгдэж байна	сэргийлэх мэдээлэл сурталчилгаанд ашиглах ДЭМБ-ийн зөвлөмж, аргачлалын судалсан байна	сэргийлэх мэдээлэл сурталчилгаа	эрсдэлт зан үйлийг өөрчлөх мэдээлэл сурталчилгааг тогтмол зохион байгуулсан байна												
<b>Зорилт 2. Халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийн бүртгэл, мэдээлэл, хяналт, тандалтын тогтолцоог боловсронгуй болгож, дэвшилтэт технологи нэвтрүүлэх</b>																			
1	Эрүүл мэндийн салбарт халдварт өвчин, түүний эрсдэлт хүчин зүйлийн бүртгэл, статистик мэдээ, мэдээллийг ашиглах, хяналт, тандалтын шинэчлэл хийх	Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журманд маягтуудыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэн мэдээ, мэдээллийг оруулах	Эрүүл мэндийн салбарын програм хангамжид Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журманд оруулсан маягтыг	Улсын төсөв, ЭМДС, ОУБ	Шинээр боловсруулсан, өөрчлөлт оруулсан маягтын тоо	Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журм, бүртгэлийн маягтын тушаалд	Халдварт бус өвчин, түүний эрсдэлт хүчин зүйлийн бүртгэл, хяналт, тандалтын тогтолцоог боловсруулсан байна	Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журманд маягтуудыг оруулсан байна	Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журманд маягтуудыг оруулсан байна	Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журманд маягтуудыг оруулсан байна	Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журманд маягтуудыг оруулсан байна	Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журманд маягтуудыг оруулсан байна	40.0	40.0	50.0	130.0	ЭМХТ	ЭМЯ, НЭМТ, УТТЭ	Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журманд маягтуудыг оруулсан байна
2	Халдварт бус өвчний мэдээллийн нэгдсэн сан бий болгох (Анхан шат, лавлагаа шат, эрүүл мэндийн даатгал, лабораторийн мэдээллийн эх	ХБӨ, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн талаарх эрдэм шинжилгээ, судалгааны мэдээллийн сан бүрдүүлэх	НЭМТ-ийн вэб сайт дахь ХБӨ тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн талаарх эрдэм шинжилгээ, судалгааны мэдээллийн сангийн баяжилт	Мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаа тогтмол, биш жигд байна	ХБӨ-ийн чиглэлээр хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгаануудыг ангилсан байна	ХБӨ-ий эрсдэлт хүчин зүйлийн тархалтын болон эрдэм шинжилгээ, судалгааны мэдээллийн сан бүрдүүлж, НЭМТ-ийн вэбсайтад	Мэдээллийн санг ЭМБ-ын удирдах ажилтнууд, нийт ашигладаг болсон байна	15.0	10.0	-	25.0	НЭМТ	ОУБ, Эрүүл мэндийн байгууллагууд	Эрүүл мэндийн байгууллагууд					

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Санхүүгийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Сүүр түвшин, он	Зорилтот түвшин			Төсөв төгрөгөөр			Нийт төсөв (сая төг)	Хэрэгжүүлэгч байгууллага			
					2026 он	2027 он	2028 он	2026 он	2027 он	2028 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч	
3	Уусваруудээс өгөгдөл татах, ICD-10 кодчлолын стандартард суурилсан бүртгэлтэй байх, мэдээллийн нууцлал ба хандалтын эрхийн зохицуулалтыг мөрдөх (тогтоолоотой)	ХБӨ-өөс сэргийлэх, хянах чиглэлээр иргэдэд зориулсан мэдээлэл сурталчилгааны мэдээллийн сан үүсгэх	Түгээсэн контентын тоо, платформ тус бүрт үзсэн тоо, хандалт контент үзэсний дараах мэдээллийн судалгаа, асуулгын үр дүн	Аймаг, дүүрэг бүрийн НЭМТ-д зургаан сарын НЭМТ-д МСС-ны цахим номын сан байгуулж, авилгах батлагдсан журам, байгуулсан номын сангийн тоо	Аймаг, дүүргийн НЭМТ-д зургаан сарын авлага материал байхгүй байна	ХБӨ-ий эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хэвлэгдсэн ЭМСС-ны гарын авлага, материалыг цуглуулж, жорсаалт гаргаж, ашиглах журам боловсруулсан байна	Хэвлэгдсэн гарын авлага материалын санг аймаг бүрт байгуулсан байна	Хэвлэгдсэн гарын авлага материалын цахим номын санг бүртгэлтэй ЭМТ-д байгуулсан байна	30.0	-	-	30.0	НЭМТ	Аймаг нийслэлийн ЭМГ, НЭМТ	ОУБ, ТББ

№ хэмжээ	Зорилтыг хэрэгжүүлэх арга	Санхүүгийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин, он	Зорилгот түвшин			Төсөв төгрөгөөр)			Нийт төсөв (сая төг)	Хэрэгжүүлэгч байгууллага		
					2026 он	2027 он	2028 он	2026 он	2027 он	2028 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч
4	ЭХЭМҮТ-ийн дэргэдэх Өсвөр үеийн эрүүл мэндийн төвд өсвөр насны хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлтийн мэдээллийн нэгдсэн сан бий болгож, дунг ЭМХТ-д мэдээлэх, ЭМХТ-ийн "Эрүүл мэндийн үзүүлэлт" товхимолд "Өсвөр үеийн эрүүл мэнд" гэсэн бүлэг бий болгох	ЭМДС, НҮБХА	ЭХЭМҮТ-ийн Өсвөр үеийн эрүүл мэндийн төвийн вэб сайт дахь эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбарын үйл ажиллагаатай холбоотой өсвөр насны хүүхдийн эрүүл мэндийн нэгдсэн үзүүлэлт бүхий мэдээллийн сан	ЭХЭМҮТ-ийн ӨСҮЭМТ-ийн Эрүүл мэндийн сайдын эрүүл мэндийн тухаалаар зөвхөн эрүүл мэндийн байгуулалуудын үзүүлэлт цугларч байна	Өсвөр үеийн хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлтийг мэдээлэх, нэгтгэх, ЭМХТ-д илгээх журам боловсруулж, ЭМ, БСЦУ, ХНХ-ын сайдын тухаалаар батлуулсан байна	Өсвөр үеийн хүүхдийн эрүүл мэндийн үзүүлэлтийг бүртгэх, мэдээлэх цахим систем боловсруулж, ашиглах сургалт зохион байгуулсан байна	ЭМХТ-ийн "Эрүүл мэндийн үзүүлэлт" товхимолд "Өсвөр үеийн эрүүл мэнд" гэсэн бүлэг бий болгосон байна	-	-	-	-	ЭМЯ,	БСЦЯ, ХНХЯ, ЭХЭМҮТ, ЭМХТ, НЭМҮТ, СЭМҮТ	НҮБХАС, НҮБХС
<b>Зорилт 3. Халдварт бүс өвчний чиглэлээрх эрдэм-шинжилгээ, судалгааг өргөжүүлэн нотолгоонд суурилсан шийдвэр гаргах орчныг сайжруулах</b>														
1	ХБӨ, осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг тогтоох "STEPS" шатчилсан үндэсний 5 дахь удаагийн судалгааг хийх	ЭМДС	Судалгааны тайлан	ХБӨ, осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлсийн тархалтыг тогтоох шатчилсан үндэсний 4 дэх судалгаа 2019 онд хийгдсэн	Үндэсний судалгаа хийх судалгааг бэлтгэл ажлыг ДЭМБ-ын аргачлалын дагуу дуусгасан байна	Үндэсний судалгааны үр дүнг танилцуулах үүлзэлт хийж, түгээсэн байна	500.0	40.0	20.0	560.0	ЭМЯ	НЭМҮТ, ГССҮТ, ХСҮТ, АШЛУИС	ДЭМБ	
2	Иргэдийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох судалгааг хийх	ЭМДС, ОУБ	Үндэсний хэмжээнд хийгдсэн "Иргэдийн эрүүл мэндийн талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох судалгаанд	АНУ-ын МСС-ийн төслөөр 1 удаа хийгдсэн судалгааны асуумж, аргачлалыг боловсруулан батлуулах, санхүүгийн тооцооллыг хийж, үүсвэрийг	Үндэсний судалгаа хийх бэлтгэл ажлыг дунг танилцуулах үүлзэлт хийж, дагуу судалгааг хэвлүүлж хийж дуусгасан байна	Үндэсний судалгааны үр дүнг танилцуулах үүлзэлт хийж, түгээсэн байна	50.0	-	-	50.0	ЭМЯ	НЭМҮТ	ТББ	

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Санхүүгийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Сүүрв түвшин, он	Зорилтот түвшин			Төсөв (сая)			Нийт төсөв (сая/ төр)	Хэрэгжүүлэгч байгууллага		
					2026 он	2027 он	2028 он	2026 он	2027 он	2028 он		Үндсэн	Хамтрагч	Оролцогч
3	Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд, тархвар судлаач, биостатистикийн нарт судалгааны загвар, арга аргачлал, хэтийн төлөв тооцох, өвчний дарамт тооцох, судалгааны програм хангамж ашиглах зэрэг чиглэлээр олон улсын шваардлагад нийцэх үр чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах, судлаачдын баг бүрдүүлэх	ЭМДС	Аймаг дүүрэг бүрт судалгааны арга зүйд бэлтгэгдсэн 5- суралцсан 10 хүний мэргэжилтэн бүрэлдэхүүнтэй байхгүй судлаачдын багийн тоо	Аймаг дүүрэг судалгааны арга зүйд судалгааны арга зүйд бэлтгэгдсэн 5- суралцсан 10 хүний мэргэжилтэн байхгүй судлаачдын багийн тоо	Судалгааны арга зүйд сургалтын хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх байгууллагыг сонгох, санхүүжилтийг шийдвэрлэсэн байна	15 аймаг, дүүргийн судалгааны багийн гишүүдийг сургалтад хамруулсан байна	6 аймаг, дүүргийн судалгааны багийн гишүүдийг сургалтад хамруулсан байна	100.0	50.0	-	150.0	НЭМҮТ	СЭМҮТ, ЭМХТ, ХӨСҮТ, ГССҮТ	Орон нутгийн ЭМГ
4	Харва, сонгогч бууралтын тархалт, шалтгааныг тогтоох үндэсний судалгаа хийх (гөрөл, шалтгаан, насны булаг, онош, тусламжийн байдал зэргээр)	Улсын төсөв, ЭМДС	Судалгааны тайлан	Судалгаа байхгүй	Судалгааны асуумж, аргачлалыг боловсруулж батлуулах, санхүүгийн тооцооллыг хийж, үүсвэрийг тодорхой болгосон байна	Үндэсний судалгааг батлагдсан аргачлалын дагуу хийж дуусгасан байна	Үндэсний судалгааны үр дүнг танилцуулах үүлээлт хийж, хэвлүүлж, түгээсэн байна	75.0	50.0	60.0	185.0	ЭМЯ	ДЭМБ, НЭМҮТ	ОУБ, ТББ
5	Ясны сийрэгжилт өвчний үеийн FRAХ асуумжийн аргыг Монгол хүмүүст тохируулан боловсруулж судалгаа хийх	ЭМДС	Аргачлал боловсруулах судалгааны тайлан	Судалгаа хийгдээгүй	Судалгааны асуумж, аргачлалыг боловсруулж батлуулах, санхүүгийн тооцооллыг хийж, үүсвэрийг тодорхой болгосон байна	Үндэсний судалгааг батлагдсан аргачлалын дагуу хийж дуусгасан байна	Үндэсний судалгааны үр дүнг танилцуулах үүлээлт хийж, хэвлүүлж, түгээсэн байна	40.0	40.0	-	80.0	ЭМЯ	АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг	Монголын Ревматологийн Холбоо
6	Үрт хугацааны ковидын үр нөлөө, хяналт анхаарах асуудлын талаар олон улсад хийгдсэн судалгаа, эрдэм шинжилгээний үр дүнг нэгтгэж, дүгнэлт гаргах, мэдээлэх	ЭМДС	Үрт хугацааны ковидын үр нөлөөний талаар дэлхийн эрдэмтдийн хийсэн судалгааны үр мэдээлэл дүнг, зөвлөмжийг нэгтгэн мэдээлсэн мэдээллийн тоо	Үрт хугацааны ковидын үр нөлөөний талаар нотлогтой мэдээлэл байхгүй байна	Олон улсын судалгааны батлалатай эх сурвалжаас мэдээллийг цуглуулсан байна	Олон улсад хийгдсэн судалгаа, эрдэм шинжилгээний үр дүнг нэгтгэж, дүгнэлт гаргаж, мэдээлсэн байна	Үрт хугацааны ковидын үр нөлөө, хяналт, анхаарах асуудлын талаар олон улсад хийгдсэн шинжилгээний үр дүнг нэгтгэж, дүгнэлт гаргаж, олон нийтэд 2 удаа мэдээлсэн байна	20.0	20.0	-	40.0	ЭМЯ	НЭМҮТ, СЭМҮТ, ХӨСҮТ	ОУБ

№ хэмжээ	Зорилгыг хэрэгжүүлэх арга	Санхүүгийн эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин, он	Зорилгот түвшин			Төсөв (сая)			Нийт төсөв (сая/төг)	Хэрэгжүүлэгч байгууллага		
					2026 он	2027 он	2028 он	2026 он	2027 он	2028 он		Үндсэн төг	Хамтрагч	Оролцогч
